



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 дугаар сарын 28

Дугаар 14/02

Баян-Өндөр сум

Өрхийн болон бичил үйлдвэрлэл,
үйлчилгээг дэмжих хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, биелэлтийн явцыг жил бүрийн I улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит XIV хуралдааны 4/0 дугаар тогтоолын хавсралт



“ӨРХИЙН БОЛОН БИЧИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Орхон аймгийн 2021 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтээр нийт 30 орчим мянган өрх, 106 мянган хүн амтай, жилд дунджаар 2,000 хүн шилжин ирдэг байна. Нийт хүн амын 62.5 мянга буюу 59 хувийг хөдөлмөрийн насны иргэд эзэлдэг. Ажиллах хүчний оролцооны түвшин 53 хувь буюу хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 53 нь тогтвортой хөдөлмөр эрхэлдэг.

Аймгийн хэмжээнд нийт 5,339 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас зөвхөн 36 хувь нь тогтвортой үйл ажиллагаа явуулдаг бол 41 хувь нь зогссон байна. Үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 81.7 хувь нь компани, хоршоо, нөхөрлөл, 6 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой болон төсвийн байгууллага, 11.7 хувь нь төрийн бус байгууллага байна. Үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл аж ахуйн нэгжүүдийн 50.7 хувь нь худалдаа, үйлчилгээний чиглэлээр, 8.7 хувь нь боловсруулах үйлдвэр болон уул уурхайн салбарт, 5.5 хувь нь барилга, 1.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй байгууллагуудын тоо олон боловч 2021 оны байдлаар аймгийн хэмжээнд жилд нийт 3.7 их наяд төгрөгийн аж үйлдвэрлэлийн орлого төвлөрүүлснээс 94 хувь нь уул уурхайн салбар, 4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 2 хувь нь эрчим хүчний салбараас төвлөрсөн байна. Үүнээс харахад Орхон аймагт өрхийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тэдгээрийн өөрөө өөртөө ажлын байр бий болгох, ажлын байраа хадгалах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бичил бизнес, халамжаас бусад орлогогүй 10 орчим мянган өрхийн 10 хувь болох 1,000 өрхийн хэмжээнд социологийн судалгаа явуулахад 75 орчим хувийн орлого нь нийслэл, аймгийн төвүүдэд амьдарч буй өрхийн дунджид, 48 орчим хувийн орлого нь Үндэсний статистикийн хорооноос тогтоосон хүн амын амьжиргааны доод түвшинд хүрдэггүй байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 60 хувь нь эмэгтэй, 40 хувь нь эрэгтэй байгаа нь харьцангуй бага орлоготой өрхөд эзлэх хүйсийн харьцаа тодорхойлогдож байна. Өрхийн гишүүдийн тооны хувьд орон нутгийн дундаж буюу нэг өрхөд 3.5 хүн амьдарч буй үзүүлэлтээс 11 хувиар илүү буюу дунджаар 3.9 хүн өрхөд ноогдож байгаа нь эдгээр өрхүүдэд чиглэсэн бодлого шаардлагатай гэдгийг харуулж байгаа бас нэг үзүүлэлт юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050”, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020-2025), Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн нийгэм, эдийн засгийн холбогдох статистик үзүүлэлтүүд, өрхийн орлого, бизнес эрхлэлтийн чиглэлээр хийгдсэн судалгааны дүн зэрэг нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл болно.

Орон нутагт бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд: “Эрдэнэтчүүд-Эрдэнэтчүүддээ хайртай” хөтөлбөрийн

хүрээнд нийт 76 төсөлд 540 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон. Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "PROGRES" төслийн хүрээнд 2021-2023 онд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлж 30 орчим төсөлд нийт 270 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтийн грант олгосон.

АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлагийн "BEST" хөтөлбөр нь 2020-2025 онд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх, бизнес эрхлэгчдийг банкны зээлд зуучлах үйл ажиллагаа явуулж, 10 хүртэлх сая төгрөгийн бичил санхүүжилтийн тэтгэлэг олгон ажиллаж байна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- 3.1. Үнэн зөв судалгаанд үндэслэн дэмжлэг нэн шаардлагатай өрхийг хамруулах, иргэний өөрийн санаачилгад үндэслэх, оролцоог хангах;
- 3.2. Үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах;
- 3.3. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, хавсарсан бус буюу тодорхой бөгөөд нэн чухал зорилго, зорилтууд, үр дүнд чиглэх;
- 3.4. Өрхийн бичил бизнес эрхэлдэг болон бичил бизнес эрхлэн амьжиргаагаа дээшлүүлэх хүсэл, эрмэлзэлтэй Орхон аймгийн иргэн хамрагдах.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАГСДАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Судалгаанд хамрагдаж үнэн зөв мэдээлэл өгөх.
- 4.2. Цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй өргөжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөтэй байх.
- 4.3. Хариуцлагатай байх. (татварын болон хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх)

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Бичил бизнес, халамжаас бусад орлогогүй өрхийн өөртөө ажлын байр бий болгох, ажлын байраа хадгалах санаачилгыг дэмжихэд хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

Хөтөлбөрийн үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

- 5.1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа гаргах, мэдээлэл хүргэх, хөтөлбөрт оролцогчдыг чадавхжуулах;
- 5.2. Бизнес эрхлэгчдэд санхүүжилт олгох, хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байраар хангах;
- 5.3. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөтөлбөрийн гурван зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа гаргах, мэдээлэл хүргэх, хөтөлбөрт оролцогчдыг чадавхжуулах зорилтын хүрээнд:

6.1.1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгааг тогтмол гаргах, мэдээллийг шинэчлэх, үр дүнг тайлагнах;

6.1.2. Хөтөлбөрт хамрагдах иргэдэд мэдээлэл хүргэх, өөрийн санаачилгаар хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх, судалгаа гаргах, сонгон шалгаруулах;

6.1.3. Бизнес эрхлэх хандлагыг идэвхжүүлэх, бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах;

6.1.4. Иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулах, ажлын байранд дадлагажуулах.

6.2. Санхүүжилт олгох, хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байраар хангах зорилтын хүрээнд:

6.2.1. Шаардлага хангасан буюу тодорхой шалгуурт тэнцсэн бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн грант олгох;

6.2.2. Томоохон худалдаа, үйлчилгээний төв, хүний урсгал ихтэй байршлуудад бүтээгдэхүүн, үйлчилгээнд шууд ашиглагдахгүй буюу дулааны зэрэг ашиглалтын зардлыг багтааж түрээсээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлын байр бий болгох.

6.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

6.3.1. Смарт Эрдэнэт платформын "Эрдэнэтийн брэнд" цахим системээр бүтээгдэхүүн худалдаалах;

6.3.2. Бизнесийн дунд шат, оюуны өмч, брэндийн зөвлөх үйлчилгээ, улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах, хоршоо болж хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;

6.3.3. Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаа, туршлага судлах болон бусад уралдаан, арга хэмжээнд оролцуулах;

6.3.4. Дамжин өнгөрөх зам дагуу "Эрдэнэтийн брэнд" дэлгүүр байгуулах;

6.3.5. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын тухайн жилийн албан хэрэгцээнд шаардлагатай бараа, бүтээгдэхүүний жагсаалт, тоо хэмжээг нийтэд ил болгох, хөтөлбөрт хамрагдсан иргэдэд мэдээллийг хүргэх, холбогдох эрх зүйн актад нийцүүлэн худалдан борлуулахад нь дэмжлэг үзүүлэх.

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2023-2026 онд буюу дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

1. Улс болон орон нутгийн төсөв;

- 2.Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;
- 3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;
- 4.Бусад эх үүсвэр.

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө оруулалттай хослуулан, хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

ЕС. ХҮРЭХ ҮР ДҮН

9.1.Шинээр 250 орчим ажлын байр нэмэгдэж, 200 орчим ажлын байр хадгалагдана.

9.2. 1,000 орчим иргэнд бизнесийн анхан болон дунд шатны зөвлөх үйлчилгээ үзүүлж 130 орчим иргэнд мэргэжил олгоно.

9.3.Бизнес эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилт, хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглах ажлын байр зэрэг шинэлэг үйлчилгээ, дэмжлэг бий болно.

9.4.Оюуны өмчөөр хамгаалагдсан болон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ тодорхой тоогоор бий болно.

9.5.Улс, орон нутагт хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөрүүдэд хөтөлбөрт сонгогдсон өрхүүд хамрагдах боломж нэмэгдэж, бизнес эрхлэгчдийг туршлага судлах, бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд хүргэх зэрэг арга хэмжээнүүдэд оролцуулна.

9.6.Өрхийн болон бичил бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх төв бий болно.

9.7.Тус хөтөлбөрт хамрагдсан иргэдээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бий болгож тоог нэмэгдүүлнэ.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

10.1.Үндсэн хэрэгжүүлэгч Хүнс, хөдөө аж ахуйн газар, хамтран хэрэгжүүлэгч Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад улирал тутам хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулж, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

10.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг жил бүр зохион байгуулна.

10.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг дарга аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын холбогдох хороо хагас жил тутам хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.

10.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркийн цахим хуудас, Erdenet.mn сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүр нийтэд мэдээлнэ.

10.5.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу жил бүр дүгнэлт гаргуулна.

АРВАН НЭГ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН УЯЛДАА, САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

Зорилт	Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа	Хэрэг-жүүлэх он	Санхүүжилт, сая төгрөг					Хэрэгжүүлэх байгууллага	
					Нийт	2023 он	2024 он	2025 он	2026 он		Эх үүсвэр
Зорилт - 1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгааг тогтмол гаргах, мэдээллийг шинэчлэх, үр дүнг тайлагнах	1	Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгааг тогтмол гаргах, мэдээллийг шинэчлэх, үр дүнг тайлагнах	Алсын хараа - 2050: 3.3.14., ЗДҮАХ /2020-2024/: 2.2.4.	2023-2026	80	20	20	20		Орон нутгийн төсөв	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк, аймаг, сумдын ЗДТГ
Зорилт - 2. Өрхийн судалгаа гаргах, мэдээлэл хүргэх, хөтөлбөрт оролцогчдыг чадавхжуулах	2	Хөтөлбөрт хамрагдах иргэдэд мэдээлэл хүргэх, өөрийн санаачилгаар хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх, судалгаа гаргах, сонгон шалгаруулах	ЗДҮАХ /2020-2024/: 2.2.4.	2023-2026	-	-	-	-	Зохион байгуулалтын арга хэмжээ	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк	

Зорилт - 2. Санхүүжилт олгох, хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байраар хангах	3	Бизнес эрхлэх хандлагыг идэвхжүүлэх, бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах	ЗДҮАХ /2020-2024/: 2.2.5.	2023-2026	20	5	5	5	5	Орон нутгийн төсөв	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
	4	Иргэдийг мэргэжил олгох сургалтад хамруулах, ажлын байранд дадлагажуулах	ЗДҮАХ /2020-2024/: 3.3.2.	2023-2026	200	50	50	50	50	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сургалтын байгууллагууд
	5	Шаардлага хангасан бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн грант олгох	Алсын хараа - 2050: 3.3.20., ТЖҮЧ /2020-2025/ 3.4.2., 3.4.7.	2023-2026	800	200	200	200	200	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк

	6	Боломжит байршлуудад түрээсээр үйлдвэрлэл, үйлчилгээний ажлын байр бий болгох	ТЖҮЧ /2020-2025/ : 3.4.6.	2023-2026	800	200	200	200	200	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк
Зорилт - 3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	7	Смарт Эрдэнэт платформын "Эрдэнэтийн брэнд" цахим системээр хувийн хэвшилтэй хамтран бүтээгдэхүүн худалдаалах	ЗДУАХ /2020-2024/ : 6.3.	2023-2024	-	-	-	-	-	Зохион байгуулалтын арга хэмжээ	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк
	8	Бизнесийн дунд шат, оюуны өмч, брэндийн зөвлөх үйлчилгээ, улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх	ЗДУАХ /2020-2024/ : 7.2.1.	2023-2026	-	-	-	-	-	Зохион байгуулалтын арга хэмжээ	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк

	9	Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаа, туршлага судлах болон бусад уралдаан, арга хэмжээнд оролцуулах	ЗДҮАХ /2020-2024/: 7.2.1.	2023-2026	200	50	50	50	50	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк
10	Аялал жуулчлалын дамжин өнгөрөх зам дагуу "Эрдэнэтийн брэнд" дэлгүүр байгуулах	Алсын хараа - 2050: 3.3.2., ТЖҮЧ /2020-2025/: 8.4.4., ЗДҮАХ /2020-2024/: 7.2.3.	2023	-	-	-	-	-	Зохион байгуулалтын арга хэмжээ	Аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк	
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН (САЯ ТӨГРӨГ)										2,100	

**АРВАН ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИН, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
				2023 он	2024 он	2025 он	2026 он
Үндсэн зорилгын хүрээнд:							
1	Шинээр бий болох ажлын байр	т00		25	65	75	85
2	Хадгалж үлдэх ажлын байр	т00		20	50	60	70
Зорилт - 1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгаа гаргах, мэдээлэл хүргэх, хөтөлбөрт оролцогчдыг чадавхжуулах зорилтын хүрээнд:							
3	Бүртгэлд хамрагдах бизнес эрхлэгчид	т00	-	5,000	-	-	-
4	Судалгаанд хамрагдах өрх	т00	1,000	2,500	2,500	2,500	2,500
5	Хөтөлбөрт хамрагдах өрх	т00	-	50	130	150	170
6	Бизнес эрхлэх хандлагыг идэвхжүүлэх, бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалт, арга хэмжээнд хамрагдах иргэд	т00	-	120	140	180	160
7	Мэргэжил олгох сургалт, дадлагад хамрагдах иргэд	т00	-	20	30	40	40
Зорилт - 2. Санхүүжилтийн грант олгох, хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байраар хангах зорилтын хүрээнд:							
8	Санхүүжилт (грант буюу шагнал) авах бизнес эрхлэгчид	т00	24	18	20	22	20
9	Хөнгөлөлттэй нөхцөлөөр хангах ажлын байрны хэмжээ	м2	-	-	450	350	350
10	Хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байр ашиглах бизнес эрхлэгчид	т00	-	30	40	50	40
Зорилт - 3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:							
11	"Эрдэнэтийн брэнд" дэлгүүрийн харилцагчид	т00	20	27	32	37	42
12	Бизнесийн дунд шатны зөвлөх үйлчилгээ авах бизнес эрхлэгчид	т00	-	60	100	120	120
13	Оюуны өмчөөр хамгаалагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээ	т00	7	жил бүр 5-аар нэмэгдүүлнэ			
14	Брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ	т00	5	7	10	13	15

15	Улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрт хамрагдах бизнес эрхлэгчид	Тоо	-	20	30	40	50
16	Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд оролцогчид	хувь	80	жил бүр 100 хувь хамруулна			
17	Туршлага судлах арга хэмжээнд оролцогчид	Тоо	-	5	5	5	5
18	Смарт Эрдэнэт платформын "Эрдэнэтийн брэнд" цахим системийн харилцагчид	Тоо	-	-	20	30	40

-- 000 --